

## Х. Чойбалсангийн эдийн засгийн үзэл санаа\*

[2. Монголын хөдөө аж ахуйг өөрчлөн хөгжүүлэх  
Чойбалсангийн үзэл баримтлал]

Даш. Төмөртоогоо

Х. Чойбалсан монгол орноо бүхэлд нь мал аж ахуйн орон гэж үздэг байв. Үнэндээ ч түүнийг монголын төр нийгмийн гол зүтгэлтэн байх цагт монгол орон бүхэлдээ нүүдлийн мал аж ахуйн орон байсан юм. Ардын хувьсгалын эхэн үед мал аж ахуй нь тус орны нийт бүтээгдэхүүний 90 орчим хувийг дангаараа үйлдвэрлэж байсан бол аж үйлдвэр, тээвэр худалдаа хэрдээ хөгжсөн 1940 он гэхэд сая 61 хувь болж ирсэн байдаг [13-116]. Тийм учраас түүний эдийн засгийн үзэл санаа, улс орныхоо эдийн засгийг хөгжүүлэх бодлогын гол нь хөдөө аж ахуй, тэр дундаа мал аж ахуйг хөгжүүлэх, малчдын аж байдлыг сайжруулахын төлөөх бодлого баримтлал байжээ.

Тэрбээр уулаасаа малчин нүүдэлчин гаралтай, бага насандаа хөдөө хонь, хурга хариулж өссөний дээр нэг үе Мал аж ахуйн яамны сайд болж явсан, бас уг язгуураас малчин монголчуудын эрх ашгийг туйлаас хичээх сэтгэлийн улмаас ч гэх юм уу ямар боловч мал аж ахуйг ихэд сонирхдог байжээ. Өөрийг нь тэр үед Монгол улсын ерөнхий сайд байсан Пэлжидийн Гэндэн Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч дарга болгохоор санал гаргаж "эцэг" Сталинтай зөвлөхөд Чойбалсан "би мал аж ахуйг туйлаас их сонирхдог" гэж хэлж татгалзаж [1-74., 102] байсан удаатай. Өөрөө байн байн хөдөө явж малчин айлд бууж гэрт нь хоньж, настан буурлуудтай эн тэгш зөв сайхан ярилцаж, хотод хашаандаа тусгай гэр барьж малчдыг хүлээн авч байнга харилцаатай байдаг байжээ. Хөдөө ажлаар явахдаа том гэртэй баян айлд буух биш өмгөр бор гэртэй ядуусын орж бай гэж шинэ цагийн залууст биечлэн захиж тэдэнтэй илэн далангүй харилцаж юм сонсож авахыг үнэн сэтгэлээсээ зөвлөж, манай орон нутгийн эрх баригчдын нэг дутагдал бол хөдөө явахдаа хоол унд, орон гэрийн тохитойг бодоод том цагаан гэртэй айлд ихэвчлэн бууж байна гэж шүүмжилж байсан гэдэг [1-75].

Ер нь монголын эртний уламжлалаар хот айлын гэрийн **өнгө, хэмжээ, байрлал** гурав нь тэдний хөрөнгө чинээ нийгмийн байдлыг шууд илтгэдэг билээ. Хот айлын хамгийн чинээлэг, ахмад, зохих төвшинд хүндлэгдсэн айл нь **баруун урд талд том, цагаан гэрээ** барьж, залуус багачуул нь хотны зүүн талд, ядуус зарц нар хотны зүүн хойгуур буудаг нь нэн эртний хүрээ нүүдлийн задралаас уламжилсан заншил юм. Энэ нь монголчуудын баруун талыг дээдлэх ёсон, ахмад үеэ хүндлэх уламжлал, цэрэг-феодлын байгууллын үлдэц гурваас эхлэлтэй гэж үзэж болно. Чинээлэг айл том гэртэй, бас жил тутам эсгийгээ шинэчилж ямагт цагаан гэртэй байсан байна. Харин ядуусын гэр жижиг, өнгө нь цагаан биш, он удсан утаатай эсгий бүрээстэй байжээ. Ер нь монгол гэрт зуух, яндан гэгч зүйл нэлээд хожуу 1940-өөд оны сүүлч 1950-иад оны эх орчимд нийтлэг болж нэвтэрсэн бөгөөд түүнээс өмнө задгай тулгатай байснаас гэрт ямагт утаа тархаж бүрээс нь аяндаа утаатай болдгоос утаанд эхлээд шарлаж, аажимдаа харладаг байсан

\* Эхний хэсэг *Acta Mongolica*, Том. 4 (236), 195-122-р талд буй.

юм. Тиймээс “муу л бол зүүн хойд захын хар овоохой” гэдэг үг гарсан гэдэг. 1940-өөд оны сүүлчээр малчин ардын дунд судалгаа хийсэн нэрт эрдэмтэн Н. Жагварал үүнийг гярхай ажиглаж, тодорхойлон монгол айлын гэрийн **өнгө, хэмжээ, байршил** гурвыг онцлон дурдаж чухаг үзүүлэлт гэж бичсэн байдаг [15-124, 125].

Чойбалсан нь монголын хөдөө аж ахуйг дан ганц мал аж ахуй хэвээр байх мэтээр сэтгэх нь эс боловч мал аж ахуйгаа өнийн уламжлалаар нь байлгах юм шиг санадаг байсан гэж хэлж болмоор. Түүний хэлсэн, бичсэн зүйлийн дотор мал аж ахуй эрхлэх системийг өөрчлөх, эрчимжүүлэх, суурьшилд шилжих, нүүдэлчдийг суурьшуулах гэх мэт нэлээд хожуу үед яригдах болсон зүйлс байдаггүй. Харин мал аж ахуйг хөгжүүлэх, боловсон аргыг нэвтрүүлэх, нэгж малаас авч ашиглах ашиг шимийн хэмжээг нэмэгдүүлэх, малын гаралтай түүхий эдийн боловсруулалтын хэм зэргэмжийг нэмэгдүүлж үр ашгийг нь сайжруулах талын үгс цөөнгүй тохиолддог.

Тэрээр нэг малаас ашиглах ашиг шимийг нэмэгдүүлэх гэдэгтээ их төлөв манай малчдын өнийн уламжлалаас хамааран авч ашиглаж чадахгүй үрэгдүүлж байгаа ашиг шимийн тухайд гол төлөв өгүүлэхээс бүс нэг малаас гарах ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэхийг гол болгосон нь бараг үгүй гэмээр. Тэгээд ч тэрбээр “ноос бол алт” гэдэг уриа гаргаж хаягдал ноос түүлгэж, цуглуулж авдаг болгож, аажимдаа мал аж ахуйн бүтээгдэхүүнийг 1941 оноос сайн дурын үндсэн дээр цаашдаа албан журмын ноогдлоор улсад бэлтгэх системийг бий болгосон юм. Үүнд нь дэлхийн хоёрдугаар дайны үе тохиолдож эдийн засгийн хүнд байдал учирсан нь түлхэц болсон нь дамжиггүй. 1941 оноос ноосыг, 1944 оноос мал, мах, 1947 оноос албан журмаар нийлүүлдэг болсон билээ. Үүнээс өмнө олон малтай зарим айл малаа бүрэн ноослохгүй, үнээдээ хүч хүрч сааж саалиа бүрэн ашиглаж чадахгүй байх нь хэвийн үзэгдэл байсан юм.

Тэр ч байтугай өнөө дэлхийн зах зээлд асар их үнэ хүрдэг болсон ямааны ноолуурыг халх даяар нийтдээ самнаж ашиглаж мэддэггүй, зөвхөн хятадтай хил нийлдэг зүүн ба өмнө зүгийн зарим нутгаар хятадууд ирж ямаа самнаж байсан гэдэг. Манай нутагт л лавтай /Өвөрхангайн Баян-Улаан сум/ ямаагаа огт самнадаггүй байсныг хуучцуул өгүүлдэг. Ямааных нь ноолуур хонгорцоглон унжсан байхад нь зулгааж аваад гуулин бурхан зүлгэхэд сэвтүүлэхгүй зөөлөн, их сайн өнгөлдөг байсан гэж ярьдаг байлаа. Харин маршал Чойбалсангийн үед л ямаагаа самнах даалгавар, ногдол ирэх болж ард олонд ямааг яаж самнахыг зааж, ямааны сам гэгч зүйлийг айлуудад тараан олгож байж билээ. Түүнээс үзвэл мал аж ахуйн түүхий эд, малын ашиг шимийг аль болох бүрнээ ашиглах, түүний боловсруулалтын зэргэмжийг нэмэгдүүлэхэд анхаарч байсан нь тухайн үедээ тулын цаг үеэ олсон бодлого байсан болно.

Мал аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын зэргэмжийг нэмэгдүүлэх эрмэлзэл нь Хатгалын ноосны фабрик [1933], Аж үйлдвэрийн комбинат [1934], Мах комбинат [1946] зэрэг үндэсний аж үйлдвэрийн суурийг тавьсан үйлдвэрүүдийг сэтгэл зүтгэл гарган байгуулахад хүргэсэн билээ. Аж үйлдвэрийн комбинат нь үнэн хэрэгтээ ноос, арьс ширний хоёр томоохон салбараар дагнасан хэдэн жижгэвтэр үйлдвэрийн нэгдэл байсан бөгөөд түүнийг Чойбалсангийн нэрэмжит болгож байв. Басхүү өвс хадлан бэлтгэж сурах талаар ихээхэн анхаарч, төр засгийн дээд албаны хүмүүс цөм хадуур барьж хадлан хадах ажлыг Бумцэнд гуайгаар заалгаж өөрсдөө суралцаад орон нутагт явж, хөдөөгийн удирдах ажилтан, малчдад зааж сургаж байсан ажээ.

Чойбалсан мал сүргийг өсгөх, малын ашиг шимийг нэмэгдүүлэх замаар малчин ардын аж байдлыг дээшлүүлэхэд ихэд анхаарч байв. Чойбалсан хэлэхдээ “тус орны нүүдлийн мал аж ахуй нь малчин ардын хувийн өмч юм. Мал нь хөдөлмөрчин ардын гарт байдаг учир тэд мал сүргийн бүрэн эзэн нь юм. Иймд хувийн хөдөлмөр дээр үндэслэсэн ардын аж ахуйтанд аль болохоор тусалж, тэдний малаа өсгөх санаачлагыг сайшаан урамшуулах хэрэгтэй. Ард нэг бүр хувийнхаа малын тоо толгойг олшруулж ашиг орлогоо нэмэгдүүлж, мал аж ахуйгаа хөгжүүлэх, өөрийнхөө төлөө өөрөө хөдөлмөрлөх хязгааргүй бололцоотой байх ёстой. Нам засаг ард нэг бүрийн малын тоо толгойг хязгаарлах байтугай, харин жил ирэх тусам нэмэгдүүлэхийн төлөө бүх ажлаа чиглүүлж байна” гэж байжээ. Тэгэхдээ малаа өсгөх хөдөлмөр нь Чойбалсангийн хэлдгээр бол зөвхөн өөрийнх нь хөдөлмөрийн үр шим байх ёстой байв.

Тэрээр “мал аж ахуйн хөгжил нь малчин бүрийн хувь хувийн санаачлага, ариун цагаан хөдөлмөрийн үр дүн байх ёстой... зөвхөн өөрийн ашиг хонжоог эрхэмлэн нөгөө этгээдийн ажлын хүчийг хөлс шагналгүй мөлжин завшиж болохгүй” гэж МАХН-ын X их хурлын илтгэлдээ хэлж

байлаа. Энэ нь үнэн хэрэгтээ мал нь нэлээд өссөн чинээлэг өрх айл цашид малаа өсгөхөд нам, төрийнхөө бодлоготой зөрчилдөх хандлагад хүргэж байв. Тэрбээр цааш хэлэхдээ "Аж ахуйн бодын тоог баримтлан ардуудыг нийгмийн хэсгүүд болгон хуваахыг намаас буруу гэж үзнэ." Чинээлэг аж ахуйтныг "нударган" хэмээн нэрлэж гадуурхдаг хандлагыг зохисгүй үзэгдэл гээд нударган гэдэг үг бол Орос улсын хөдөөд өөрийн аж ахуйг эрхлэхдээ ядуучуудыг мөлжих боолчлох замаар яваа баялаг тариачдыг нэрлэдэг байжээ. Гэтэл манайханд энэхүү "нударган" гэдэг үгийг аваад, харин бүх чинээлэг ардуудыг нударган гэж нэрлэж улсын дайсан мэтээр үзэх болжээ. Бусдыг мөлжигч этгээдийг "нударган" гэж нэрлэх бөгөөд харин олон малтай ардуудыг мөлжигч этгээд гэж нэрлэж үл болно" гэж хэлж байв. Ингээд малчдыг малаа өсгөх, чинээлэг сайхан аж төрөхийг дэмжих бодлого явуулахдаа аль болохоор малаа өсгөхийг уриалан дэмжиж улмаар дөч тавиад оны хооронд гурван ч удаа сайн малчдын зөвлөгөөнийг явуулж, 1944 оноос улсын мал аж ахуйн албан таварын хуулийг өөрчилж, ардын хувийн аж ахуйтнаас малынх нь тоог харгалзан өсгөн нэмэгдүүлэх татвар авдаг байснаа өөрчлөн малын тоо толгой тутамд нь адил хэмжээний татвар ноогдуулах болсны дээр 1944 оноос мянга, таван мянга, арван мянган малтай болсон малчин ардуудад улсын сайн малчин цол, гурван зэрэгтэй шагнал, олгож монголчуудын эрхэмлэн дээдэлж ирсэн мөнгөн хувин, мөнгөн буур, бух, хуц зэрэг дурсгалын зүйл хадгалуулах болсон юм.

Тухайн цаг үеийн байдлыг тусгасан "Хоёр малчны уралдаан" гэдэг цоглог дуунд "Малаа мянга хүргээд, Маршалдаа үнэлэгдээд, малчны хуралд очно доо" гэж дуулдаг билээ. Энэ дууг манай залуу дуучин Л. Цогзолмаа, Д. Пүрэвдорж [өнөө ардын жүжигчин, хөдөлмөрийн баатар болцгоосон] нар дэлхийн залуучууд оюутны Анхдугаар их наадамд очихдоо хоршин дуулсан нь кино хальсанд үлдсэн бий. Одоо ч энэ дууг дуулцгаадаг. Тэр үед малчид чухам л малаа мянгад хүргэхийн тулд янз бүрийн аргаар хичээх болсон байна. Энэ арга хэмжээ нь хэсэг зууртаа ардын хувийн аж ахуйтны малаа өсгөх эрмэлзлийг хөгжөөн малчдын аж байдлыг сайжруулахад түлхэц болсон боловч төдөлгүй зарим талаар дутагдалтай нь тодорсон байна.

Сайн малчдын зөвлөгөөн хийхэд зөвхөн мянгаас дээш малтай хүмүүс л цугладаг тул малаа сайн малладаг жинхэнэ сайн малч, ажилч зүтгэлтэй дунд чинээнийхэн нь орхигдож байв. Тэд зөвхөн улсын зөвлөгөөн, улсын сайн малчин цол тэмдэг, урамшлаас гээгдэх төдий биш ерөөсөө малаа өсгөсөн хөдөлмөр нь зөв үнэлэгдэхгүй байлаа. Хоёр зуун малтай малчин үнэхээр сайн ажиллаж малаа хоёр дахин өсгөвч мянган малтай малаа арван хувь өсгөсний хэртэй үнэлэгдэхгүй байжээ. Үнэн хэрэгтээ сайн малчдын зөвлөгөөн, тэрхүү шагнал нь мянгаас дээш малтай хүмүүст л үйлчилдэг болсон байна. Тэд мал худалдан авах, бусдаар малаа маллуулах, хөлсний хөдөлмөр хэрэглэх гэх мэтээр малынхаа тоог өсгөөд өөрөө сайн малчин мэтээр алдарших явдал ч гардаг байв. Энэ мэт байдал нь нийт малчдын дийлэнх болж байсан дунд чинээний ба дундаас доош хөрөнгө малтай хүмүүсийн сэтгэлд таатай нөлөө үзүүлээгүй нь мэдээж. Чухамдаа энэ бодлого нь П. Гэндэнгийн "Баяжигтун" гэдэг уриаг сэргээн хэрэглэсэн мэт байдалд хүрсэн гэмээр байдаг.

Ингээд малаа аль болохоор мянгаас дээш гаргаж өсгөхийг хичээсэн зарим малчид шүүмжлэлд өртөх болсны илрэл нь тавиад оны үед монголын уран зохиолын шүүмжлэл судлалын нэгэн судлагдахуун болж байсан "Туулын тул" гэдэг найраглалын баатар Баянзүрхийн Бадам гэгч Төв аймгийн Баянзүрх сумын чинээлэг малчин юм. Түүнийг малаа өсгөхдөө хөлсний хүч хэрэглэв, сааль сүүгээ хот суурин газарт оруулж борлуулав гэх мэтээр шүүмжлэн шүлэглэж уран зохиолын баатар болгосон нь тухайн үедээ шуугиан болж байлаа. Энэ зохиолд малчин Бадамыг Туул голын том тул загас мэт жижиг жараахай, загаснуудыг үмхдэг гэсэн байдлаар шүлэглэн шүүмжилсэн байдаг. Тэрчлэн Увс аймгийн баян ард Иргэлийг элдэвчлэн гоочилж мөлжигч, хөрөнгөтөн мэтээр нэрлэж, нутгийн ард олны сэтгэл сөв суулгаж байв. Иргэл баян хэдүй түм шахсан малтай боловч сувдаг сэтгэлгүй, хонио нутгийн ардуудад "түрээсийн" гэхээр эгэл аргаар маллуулдаг, зүүн эхээс гучин төл бойжуулж өгөөд илүүг нь малчин айл өөрөө хөлс болгон авч тэнхэлжиж малжихыг хичээ гэж хэлдэг, мах, сүү, ноосны ногдлыг улсад нийлүүлэн илүү гарсныг нь малчинд нь үлдээдэг, өөрөө бусдаас ялгарахгүй эгэл боргил аж төрлөөр амьдардаг хөдөөх монгол эр байсан гэдэг. Түүний малыг маллаж аж төрж байсан ардууд түүнийг мөлжигч, хөрөнгөтөн, нударган гэх мэтээр нэрлэж байгаагүй гэх билээ. Ямар боловч Иргэл баян Итгэлт баянаас өөр байсан бололтой. Иргэл баяны ижил эгэл монгол сэтгэхүйтэй чинээлэг малчин олон байсныг тавиад онд шүүмжилж шогчилдог байсан бол гуч, дөчөөд оны

үед элдэвчлэн хавчиж, мал хөрөнгийг нь удаа дараа хурааж, өөрсдийг нь хэлмэгдүүлж байжээ.

Архангай аймгийн Цэнхэр сумын чинээлэг ард Буяндэлгэрийн Норовыг нударган баян гэж мал хөрөнгийг нь гурван удаа хурааж, өөрийг нь феодал угсаатай хэмээн баривчлахад, малыг нь маллаж аж төрдөг байсан малчин ардууд эсэргүүцэж, Норов нь хэдүй Заяын гэгээний шавийн зайсан Буяндэлгэрээр овоглодог боловч түүний дагавар хүүхэд гэдгийг нь тодорхойлон өргөдөл гаргаж суллуулж байсан гэдэг. Ард Норов нь хэдүй хойд эцгийн гар харж өссөн дагавар хүү боловч, эх эцгийн зөв ухаан, өөрийн малч ажилч зүтгэлээрээ малжсан, нутгийн олон нь түүнийг Мөнгөн Норов гэж хэлдэг хэрдээ хөлжсөн ард байжээ.

Ер нь хөрөнгөлөг ардыг хавчих, ядуусыг дэмжих бодлого удтал үргэлжилж байснаас **ядуурлын сэтгэлгээ** дэлгэрч байсан гэж үзэж болно. Тиймээс чинээлэг ардыг элдэвчлэн хавчих үзэгдэл нэлээд хожуу болтол тасрахгүй байснаас зарим нь малаа өсгөхийг төдийлөн чармайхгүй, үрж зарах, ах дүүс хамаатан садныхаа нэр дээр тоолуулах, ёс төдий өрх тасалж өмч хуваасан дүр үзүүлэх гэх мэт байдал гардаг байв. Тэрчлэн аливаа хүн өөрийгөө доод давхаргын гаралтай болгож зориуд "ядуу малчны хүү" гэж онцлон тодруулж намтар түүхээ бичдэг зуршил газар авсан байлаа. Энэ байдал нь уран зохиол, дэлгэцэд гойд дүрслэгдсэнийг С.Удвал, Дожоодорж нарын зохиол "Хүргэн хүү" киноноос тод харж болно.

Маршал Чойбалсан малчдыг малаа өсгөж, аж байдлаа өөрсдийн хүчээр сайжруулж чадна гэж үзэж, мянган малтан болох эрмэлзэл нь нийт малын тоог өсгөж, малчдын аж байдлыг сайжруулах түлхэц болно гэж үзэж байжээ. Гэтэл түүний энэ санаа нь мөнөөхөн "хөрөнгийн бус зам"-ынх нь зорилт лугаа харшилдаж мал аж ахуйгаа өөд татаж малчдын амьдралын төвшнийг дээшлүүлэхээр мал нь аяндаа өсөөд чинээлэг айл өрх олширч тэд малаа маллахад хүч хүрэлцэхгүй бол хөлсний хүч хэрэглэх болохоор "**мөлжлөг**" гэгч "хадны мангаа" үүсэж хөрөнгөтний бус зам нь алдагдчих нь гэсэн эргэлзээ төрдөг байсан бололтой. Нөгөө талаар мянган малтан олшроход нийт малчдын аж амьдрал сайжрах биш харин дунд чинээний аж ахуйтан цөөрөх, нийт малын тоо нь буурах хандлага илэрч чинээлэг аж ахуйтны гарт ихээхэн тооны мал хуримтлагдаж аяндаа хөлсний хөдөлмөр хэрэглэхэд хүрдэг байдал мэдрэгдэх болсон байна. Иймээс Чойбалсан чинээлэг аж ахуйг дэмжих саналаасаа 1950 он гэхэд ухрахад хүрсэн [1-80], [15-215] гэдэг.

1940 онд МАХН-ын X их хуралд тавьсан илтгэлдээ Чойбалсан мал аж ахуйн байдлыг шүүмжилж улмаар их хурлын тогтоолын мал аж ахуйн талаарх заалт бүхий хэсэгт "намын төв хороо нь мал аж ахуйг хөгжүүлэх ажлын чухлыг анхаарч нам ба ард түмнийг зохион байгуулж чадсангүй бөгөөд мал аж ахуй нь зөвхөн урсгалаар явж ирснийг тус хурлаас тэмдэглэнэ" гэжээ. Мал аж ахуйн энэ урсгалаараа явж ирсэн шалтгааныг Чойбалсан ажлын зохион байгуулалтын дутагдал, малчдын хойрго залхуу байдал, дайсан этгээдийг явуулга гэх мэт зүйлээр тайлбарлаж цаашид том аж ахуй байгуулах, нийгэмчлэх, хоршооллын байгуулалд дэвших, өмчийн хэлбэрийг өөрчлөх гэх мэт шинэлэг санал төрөхгүй байсан мэт.

Монгол орны хөдөө аж ахуйг өөрчлөн хөгжүүлэх хэтийн төлөвийн асуудлаар Чойбалсангийн баримталж байсан үзэл нь нүүдэлч малчдыг хот айлын уламжлалт хэлбэрээр хөдөлмөрөө хоршиж урьдын аясаар нүүдэллэн аж төрөх мөртлөө **хэтийн төлөвлөгөөтэйгөөр** малаа өсгөж улсад мал аж ахуйн бүтээгдэхүүнээ төлөвлөгөөтэйгөөр нийлүүлдэг байх гэдэг төсөөлөлтэй байсан бололтой. Түүний энэ үзэл санаа нь юуны өмнө малчдыг 30-аад оны үест хамтралжуулах нэрээр хэт хавтгайруулан хоршооллож мал аж ахуйг уналтад оруулан малчдын сэтгэлд сэв суулгаснаас үүдэлтэй мэт бөгөөд басхүү хөдөө аж ахуйн хоршооллын болон улс нийтийн өмчит аж ахуйн талаар онолын тодорхой мэдлэг, үзэж харсан туршлагагүйтэй нь холбоотой гэмээр байдаг. Ю. Цэдэнбалын хувийн тэмдэглэлийн дэвтэрт "... 40-өөд оны сүүлчээр аажмаар хоршоолох зайлшгүй шаардлага үүссэнийг Чойбалсан ойлгохгүй, айж болгоомжилж байсан нь үнэн. Тэр 30-аад оны нугалааг өнөөдөр давтахаас айдаг байсан" /16-22/ гэх мэтээр бичсэн бий.

X. Чойбалсан малчдын хоршооллын тухай ярихдаа "ардын нөхөрлөл", "ардын нэгдэл", "ардын үйлдвэрлэлийн нэгдэл", "сүрэг мал", "улсын сүрэг" гэх зэрэг нэр томъёо хэрэглэх бөгөөд хөдөлмөрөө хоршин хамтарч ажиллахыг дэмживч хамгийн гол нь өмч хөрөнгөө хоршиж нэгтгэхийг төдийлөн зөвлөхгүй байв. Чойбалсангийн энэ санааг зарим судлаачид "тэрхүү

нөхөрлөл буюу хот айл гэдгээрээ тэрбээр, одоогийн хэлээр ярьвал фермерийн аж ахуйн хэвшлийг зөн билгээрээ төсөөлж байсан шиг байгаа юм” гэсэн байдаг [15-123].

Тухайн цаг үед улс орны замнаж байсан нийгмийн байгууллын онол, баримтлалтай нь зөрчилдөж байсан тул тэр цагт монголын мал аж ахуй дахь хот айлыг фермерийн аж ахуйн байдлаар хөгжүүлэх нийгэм - улс төрийн нөхцөл бүрэлдэх боломжгүй байжээ. Чойбалсан малчдын малыг хоршоолон нийгэмчлэхэд тааламжгүй хандаж хувийн өмчтэй хэвээр нь цаашид хөгжүүлэх санаа сэдлийг эрэлхийлэн янз бүрээр оролдож онож, алдаж байсан бололтой юм. Чойбалсангийн тэрхүү “улсын сүрэг” гэдэг нэр томъёо нь манжийн эзэрхийллийн хуучин монголд байсан “төмөр сүрэг” юм уу “жасын мал” шиг “сангийн мал” байсан юм биш байгаа гэж санагдуулдаг. Энэхүү “төмөр сүрэг” нь Манжийн хааны хөрөнгө гэх бөгөөд монгол нутагт байнга байлган малчдаар маллуулж, төмөр мэт огт хорогдолгүй, ямагт өсөж байх, хэрэв хорогдуулбал малчид өөрийн хөрөнгөөр төлж байх үүрэгтэй сүрэг байсан юм. Жасын мал нь монголын сүм хийдүүдийн аж ахуйн мал байсан бөгөөд мөн ардууд хөлсөөр маллаж, өсгөж үржүүлэх даалгавар хүлээлгэдэг байсан билээ.

Малчдын малыг нийгэмчлэхгүйгээр өсгөх Чойбалсангийн санааг хэрэгжүүлэхэд аяндаа чинээлэг аж ахуйнууд үүсэж байсан нь хөрөнгөтний бус замын зорилтод нь харшлах **жигжиг хөрөнгөтний үзэл** [15-15] гэгч ойлголтыг үүсгэж байсан бололтой. Энэхүү жигжиг хөрөнгөтөн нь өөрийн өсөлт хөгжилтөөр аяндаа хөрөнгөтөн ангийг төрүүлж байхын хамт нөгөө талдаа ядуурсан мөлжигдөгч ангийг бас үүсгэдэг гэж үзэж Ю. Цэдэнбал түүнд тусгайлан лекц уншиж [15-214] мал аж ахуйд хоршооллын хэлбэрийг хөгжүүлэх санал баримталж түүнээ санал болгож байсан ажээ. Чойбалсан яаран малчдыг хоршоолон нэгдэлжүүлэхийн оронд малчин өрх болгонд улсын төлөвлөгөө өгч мал аж ахуйг төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх санал тавьж байв. Түүний энэ саналыг нь хүлээн зөвшөөрөхгүй сөрж эсэргүүцэгчдийн дотор Ю. Цэдэнбал төдийгүй тухайн үед Улсын төлөвлөгөөний комиссын орлогч даргын тушаалд Маршал Чойбалсангийн саналаар томилогдоод байсан эдийн засгийн ухааны анхны ганц эрдэмтэн Н. Жагварал ч оролцож маршалын саналыг сайшаахгүй байсан бололтой байдаг. Чойбалсан малчдын малыг хоршооллохоос хойш суухдаа дан ганц өөрийн саналаар зүтгэсэн биш юм. “Товчоор хэлэхэд Ю. Цэдэнбал, Н. Жагварал нар нэг тал болж Чойбалсан ба сайн малчид нөгөө тал болж битүү тэмцэлдэж” [15-214] байсан гэж судлаачид үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл, хоршооллон нэгтгэх бодлогыг сайн малчид бас дэмжихгүй, улсын төлөвлөгөө авч мал өсгөж чадна гэж санацгааж Чойбалсанг дэмжиж байсан бололтой юм.

Ингээд 1947 онд МАХН-ын XI их хурлаар анхдугаар таван жилийн төлөвлөгөөний удирдамжийг батлахдаа ардын аж ахуйтанд мал өсгөх төлөвлөгөө гардуулах тухай асуудал авч хэлэлцсэнгүй, зөвхөн аймаг, сум, багийн хэмжээнд мал өсгөх ерөнхий хяналтын тоо өгөх чиглэл гаргасан байна. Гэтэл Чойбалсан 1948 онд болсон сайн малчдын зөвлөгөөнөөр өнөөх төлөвлөгөөтэй хөгжүүлэх саналаа тавьж тэднээр дэмжүүлэн гурван сарын дараа хуралдсан Улсын IX их хурлаар ардын аж ахуйтан өрх нэг бүрт малын тоог жил тутам заавал өсгөх тухай хуулийн төслийг сайшаасан шийдвэр гаргуулж улмаар энэ үндсэн дээр Улсын Бага хурлын тэргүүлэгчид “Ардын аж ахуйтанд мал өсгөх төлөвлөгөөг тогтоох тухай” хууль батлан гаргасан байдаг. Энэ хуулийн үндсэн дээр малчин өрхийн оны эцэст тоолуулсан малын нас хүйсийн бүтцэд суурилан сүргийн эргэлт зохиож өрх болгонд төлөвлөгөөт даалгаврын дэвтэр гардуулан хууль ёсоор малаа өсгөх үүрэгтэй болгосон билээ. Ийнхүү малчин өрх тус бүр бэлэн тоолуулсан малдаа татвар ногдол төлөх бус төлөвлөгөө ёсоор байвал зохих малын тоондоо тохирсон хэмжээний алба ногдол төлөх болсон тул нэг мал хорогдуулбал цаашид улам хүнд байдалд ордог болсон юм.

Энэ шийдвэрийг гаргахад Ю. Цэдэнбалыг “**голлох үүрэг гүйцэтгэсэн**” гэж үздэг хүн ч байдаг юм билээ [17-14]. Магадгүй социалист эдийн засгийн онолыг суралцсаныхаа хувьд Ю. Цэдэнбал төлөвлөгөөт эдийн засгийн хөгжлийн талаар Х. Чойбалсангаас илүү мэдлэг, мэдээлэлтэй байж энэ талаар санаачлага гаргаж байсан байж ч болох юм. Гэхдээ МАХН-ын түүх болон судалгааны зарим бүтээлд энэхүү үйл явдлыг Чойбалсангийн санаачлага гэж бичсэн нь олонтаа байдаг. Чухамдаа бол жигжиг өмчтөн нүүдэлчдийг хэтийн төлөвлөгөөтэй хөгжүүлэх оролдлого нь амьдралд нийцгүй байсан байна. Тийнхүү малчдад төлөвлөгөө өгөх асуудлаар Чойбалсангийн санаа амарсан ч малчид хохиров. Цөөн малтай ядуу өрхүүд, ам бүл олонтой ч өвгөд эмгэд мэт хүн бүл муутай зарим айл өрх яагаад ч мал өсгөх төлөвлөгөөг биелүүлж, 20

хувь малаа өсгөх нь байтугай хорогдуулсан байв. Ингээд хорогдсон малын тоогоор улсад тушаах мах, сүү, ноосны дутагдал үүсэж, дараа жил нь байхгүй малын төл нэхэгдэх, улмаар хоёр малын ашиг шимийн дутагдал үүсэх болно. Ингээд олон мал хорогдсон бол жил өнжихөөр улам дааж давахгүй өр дутагдал гарч улсын төлөвлөгөө тасалсан өөрөөр хэлбэл хууль зөрчсөн хэргээр малчид ял хүлээж хэрэгт орох болсон билээ. Энэ бэрх асуудал хэдэн жил үргэлжилж Х. Чойбалсанг нас элсэн хойно 1954 оны 3 дугаар сард МАХН-ын Төв хорооноос тогтоол гаргаж уг хуулийг өөрчлөхийн чухлыг заасныг үндэслэн БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн зарлиг гарч уг хуулийг өөрчилсөн байна. Тэрхүү зарлиг хэрэгжиж, ял эдэлж байсан малчин ардууд суллагдан шуудангийн машинаар нутагтаа ирцгээж байхыг мэдэх хүн надаас гадна өнөө байгаа биз ээ.

Ардын хувийн жижиг аж ахуйг хэтийн төлөвлөгөөгөөр хөгжүүлэх Чойбалсангийн санаа алдаатай байсныг амьдрал харуулсан юм. Мал аж ахуйн талаар Чойбалсангийн баримталж байсан бодлого дотор өөр нэг алдааг тэмдэглэж болох бөгөөд тэрээр Сталины хэлсэн үгийг ягштал баримталж монголын малыг 200 саяд хүргэнэ гэж намын Х их хурал дээр илтгэж, хурлын шийдвэрт тусгаж цаг үеийн зорилт болгон дэвшүүлж байсан юм. Гэтэл манай орны бэлчээрийн ургамлын нийт гарц буюу мал бэлчээн тэжээх чадварыг эрдэмтэд хонин толгойд жишиж бодсоноор 40-60 сая толгой малын даацтай гэж тогтоосон байдаг. Бэлчээрийн, нүүдлийн аргаараа мал аж ахуйг эрхэлдэг хэвээр буй нөхцөлд үүнээс олон мал маллах боломжгүй. Гэтэл Чойбалсан мал аж ахуйг эрхлэх системийн дэвшил өөрчлөлтийн талаар элдэв санаа сэдэл дэвшүүлж байсангүй бөлгөө. Тэгэхлээр энэ маань зүүд зөнд л байж болохоор мөрөөдөл болой.

Мал аж ахуйд хоршооллын байгуулал бий болгохыг алгуурлаж байснаар Чойбалсангийн үед их төлөв, ардын нөхөрлөл, ардын үйлдвэрийн нэгдэл, жингийн нэгдэл зэрэг малчин ардын хөдөлмөрийг хоршсон, үйлдвэрлэлийн нэгдмэл үйл ажиллагааг түр зуурын их ажлын үед явуулдаг өмчийн буюу үйлдвэрийн хэрэгслийн нэгдэлгүй жижиг нэгжүүд байгуулагдаж байжээ. Тэд жин тээх, хадлан хадах, хашаа барих гэх мэт ажлыг хамтран хийгээд хөлс авсан бол хувааж аваад, малаа тус тусдаа маллан аж төрдөг өмчийн нэгдэлгүй ажлын хөлсөө хоорондоо тэгшитгэн хувааж авах нь нийтлэг шинж болсон, хөдөлмөрийн хоршил байжээ.

Харин сүүлийн жилүүдэд нэгдлийг эрхбиш дэмжиж нэгдэл байгуулсан малчидтай уулзаж, тэдэнтэй зөвлөлдөх, бас хөдөө аж ахуйг хоршооллохын төлөө тууштай үзэл баримтлагч Ю. Цэдэнбал түүнд бүтэн найман цагийн туршид энэ сэдвээр тусгайлан лекц унших, 1947 онд хоршооллын асуудлаар тусгайлан захидал бичиж Бүх Холбоотын Коммунист намын Төв хороонд илгээж нэг хувийг Чойбалсанд өгсөн гэх мэтээр нөлөө үзүүлснээр түүний үзэлд зарим өөрчлөлт гарсан бололтой. 1951 оны 4 дүгээр сард нэгдлийн үлгэрчилсэн дүрмийг шинээр зохиох их олон хүний бүрэлдэхүүнтэй комисс байгуулсан боловч [15-215] санаанд хүртэл ажиллаагүй юм уу, өөрөө уг дүрмийн төслийг нь машид чармайн боловсруулж амралт чөлөөгүй сууж байснаас эрүүл мэнд нь цочир түргэн муудсан бололтой байдаг. Тэрээр "... гол төлөв өглөөний 4-5 цагийн үед унтаж амардаг заншилтай болсон... 1951 оны намар 8 хоног сууж нэгдлийн дүрмийг боловсруулж ажилласан ба 9 дэх шөнө бага зэрэг халуурч эхэлсэн. Энэ бол 11 сарын 25-ны өдөр байлаа" гэж гэргий нь өгүүлсэн байдаг [1-202].

Нэгдэл байгуулж малчдыг хоршооллох болохоор Чойбалсан нийгэмчлэх малын тоонд биш, харин малчдын аминд нь үлдээх малын тоонд нь гол анхаарлаа тавьж байжээ [1-86]. Чойбалсан хэлэхдээ "Хувийн ашиглалтад зориулсан аж ахуйд нь үлдээж буй 50-100 толгой мал нь бүлээр тааруу айлын амьдралыг залгуулаад байж болох юм" гэсэн байх бөгөөд үүнийг нь дүрмийн төсөл боловсруулж буй комиссын бусад гишүүд ч хүлээн зөвшөөрсөн байна [1-87].

Нэгдэлжих хөдөлгөөн өрнөж оршин тогтносон дөч илүү жилд малчдын амины малын тоо дунджаар 75 толгой байсан билээ. Үүнээс илүү олон малтай бол малчин хүн нийгмийн хөдөлмөр эрхлэх боломжгүй, харин цөөн малтай бол хэвийн байдлаар аж төрөх чадваргүй болох байв. Хөдөө аж ахуйд хоршооллын байгуулал бий болгох анхан үед малчдын нийгэмчлэх мал тоог тогтоох янз бүрийн хувилбар санал гарч байжээ. Малыг нийгэмчлэх арга хэлбэр, тоо хэмжээг тогтоох нь урьд өмнө бусад орон газарт байгаагүй хэрэглэх бэлэн туршлагагүй, зөв оновчтой шийдвэрлэхгүйгээр хөдөө дэх улс төр, нийгмийн асуудлыг зохистой шийдэхэд хүчтэй нөлөөлөх эгзэгтэй асуудал байсан юм. Малчдын малын 30-40 хувийг нь нийгэмчлээд үлдэх хувийг нь хувьд нь хэвээр үлдээх бас малчин айлын ам бүлийн тоог харгалзан аминд нь үлдээх

малын тоог тогтоох хувилбар ч гарч байсан билээ. Тэр ч байтугай малчдын малыг хураах балмад замд орох яриа ч гарч байсан гэж Ю. Цэдэнбал бичсэн байдаг [18-205]. Харин Чойбалсангийн дээрх саналыг харгалзан "нэгдэлд элсэгчдийн хөрөнгө чинээний байдлыг харгалзахгүйгээр амины өмчийн малын тоог цөмд нь адил хэмжээтэй тогтоож, түүнээс илүү гарсан бүх малыг нийгэмчлэх замаар ардын хувийн жижиг нүүдлийн мал аж ахуйг социалист ёсоор өөрчлөн байгуулсан монгол хувилбар анх ингэж бий болсон бололтой" гэж судлаачид үзсэн байдаг [1-87].

Чойбалсан хөдөө аж ахуйн асуудлыг зөвхөн мал аж ахуй, малчдын асуудлаар хязгаарлаж байгаагүй, мал аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлэх, сангийн аж ахуй байгуулах, тариалан хөгжүүлэх гэх мэт олон асуудлаар өөдрөг үзэл баримтлалтай байсан юм. Тэрээр Зөвлөлтийн тусламжаар анхны өвс хадах морин станцуудыг байгуулж, мал аж ахуйн түүхий эдий боловсруулах аж үйлдвэрийн газруудыг бий болгож, үндэсний аж үйлдвэрийн суурийг тавихад чухал үүрэг гүйцэтгэсэн бөлгөө. Гэхдээ "улс орныг аж үйлдвэржүүлэх талаар Чойбалсангийн дэвшүүлсэн онол, практикийн ач холбогдолтой томоохон санал, санаачлага гэхээр зүйл ховорхон" гэж судлаачид үнэлсэн байдаг [1-88].

Тийм боловч улс орныхоо хөгжлийн тухайн цагийн бололцооны хэрээр мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах үйлдвэрийн газар байгуулан ажиллуулж, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн нийлбэр бүтээгдэхүүний хорь орчим хувийг аж үйлдвэрийн салбар гаргах хэмжээнд хүргэж чадсан билээ. Энэ хугацаанд олон хот суурин бий болж, орчин үеийн харилцаа холбоо, эмнэлэг сургууль байгуулагдан, авто тээвэр, төмөр зам бий болж, үндэсний ажилчин анги, сэхээтний давхраа үүсэж бий болох эхлэл тавигдаж байсан боловч, хүн амын ангийн бүрэлдэхүүнд эрс дэвшил гарах, эдийн засгийн салбарын бүтцийг өөрчлөх хэмжээнд хүрээгүй болой.

Х. Чойбалсангийн үед монгол орон бүхэлдээ хөдөө аж ахуйн, тэр дундаа нүүдлийн мал аж ахуйн орон хэвээр байлаа. Ю. Цэдэнбал, монголын хөдөө аж ахуйг "шинжлэх ухааны үндсэн дээр хөгжүүлнэ" гэж [18-34] үздэг, Лениний хоршооллын төлөвлөгөөний онол сургаалын дагуу социалист ёсоор хоршооллохыг гол болгож байсан ахуй Х. Чойбалсан энэ асуудалд ихээхэн болгоомжтой хандаж байжээ.

## АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ

- Ш. Агваан, Х. Чойбалсан ба дотоод явдлын яам, УБ., 1991.
- Б. Банзрагч, Ю. Цэдэнбалын оноо, алдаа, хувь хүний онцлог, УБ., 2001.
- Л. Бат-очир, Чойбалсан (Намтрын нь балархайг тодруулахуй ...) УБ., 1996.
- Киян Жүгдэрийн Бор, Монголын тусгаар тогтнолын гэрэл, сүүдэр, УБ., 1996, ред. Г. Төмөрчулуун.
- Гэрэл сүүдэр, Ю. Цэдэнбалын хувийн тэмдэглэлээс, УБ., 1992.
- Д. Даш, Солийн Данзан, УБ., 1990.
- Н. Жагварал, Амьдрал, үйл, үзэл баримтлал, УБ., 2000, Хэвлүүлсэн Ц.Отхон.
- Н. Жагварал, Аратство и аратское хозяйство, УБ., 1974.
- Коминтерн ба Монгол, УБ., 1996.
- О. Латтимор, Нүүдэлчид ба хувьсгалчид, УБ., 1994.
- Монгол ардын хувьсгалт намын тогтоол шийдвэр, баримт бичгүүд 1, УБ., 1981.
- Монгол Улсын төр, цэргийн гарамгай зүтгэлтэн Гэлэгдоржийн Дэмид, УБ., 2001.
- М. Ринчин, С. Ичинноров, Г. Дүйнхэржав, Хорлоогийн Чойбалсангийн түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, байр суурийн асуудалд, Өгүүлэл "Засгийн газрын мэдээ" сонин, 1991 оны 5 дугаар сар, №16, 17, 18.
- Социалист эдийн засгийн түүх, УБ., 1985.
- Д. Төмөртоогоо, Хөгжлийн капиталист бус зам /эдийн засгийн асуудлууд/, УБ., 1984.
- Ю. Цэдэнбал, Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг, III боть, УБ., 1967.
- Х. Чойбалсан, Д. Лосол, Д. Догсом, Монголын үндэсний хувьсгалын үүсч байгуулагдсан товч түүх, УБ., 1979.
- Б. Ширэндэв, Далайн давалгаанаар, УБ., 1993.